



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

**Ёс зүйн хороо байгуулах тухай**

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын, орон тооны бус “Ёс зүйн хороо”-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн хорооны дарга:	Захиргаа санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Хөнгөн үйлдвэрийн технологич инженер
Нарийн бичгийн дарга:	Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

2. Төрийн албан хаагч нарт ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж, сахилга хариуцлагыг дээшлүүлж ажиллахыг Даргын зөвлөлд даалгасугай.

ДАРГА  Х.ЭРДЭНЭБИЛЭГ

УЛААНБААТАР ХОТ  
ЭМЭЭЛТИЙН  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ  
ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ  
ТТТ2340 ф.к. 8151709

3150607056